



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2012 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Нүүдэлчдийн өвөл 2012 “Мөсөн шагайн наадам” зохион байгуулах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2009 оны 4/22 дугаар тогтоол, 2005 оны 49 дүгээр тогтооолоор батлагдсан Улаанбаатар хотын аялал жуулчлал-2015 хөтөлбөрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. "Улаанбаатар хотын аялал жуулчлал-2015" хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах Улаанбаатар хот орчимд жуулчдын сонирхолтыг татах, үндэсний ёс заншил, тоглоом наадгайг гадаад, дотоодын жуулчидад сурталчилан таниулах, өвлийн арга хэмжээг зохион байгуулж хөгжүүлэх, уламжлалт арга хэмжээтэй болсоноор аялал жуулчлалын улирлын хамаарлыг багасгах зорилготой Нүүдэлчдийн өвөл 2012 "Мөсөн шагайн наадам"-ыг 2012 оны 02 сарын 25-ны өдөр Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт зохион байгуулахыг эвент хариуцсан мэргэжилтэн /Г.Нямцогт/-д үүрэг болгосугай.

Хоёр. Нуудэлчдийн өвөл 2012 "Мөсөн шагайн наадам"-ыг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, үйл ажиллагааны төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Нуудэлчдийн өвөл 2012 "Мөсөн шагайн наадам"-ыг зохион байгуулах зардал 2.500.000 /хоёр сая таван зуун мянга/ төгрөгийг тус газрын 2012 оны төсвөөс гаргахыг нягтлан /П.Ариуннаа/-д зөвшөөрсгүй.

Дөрөв. Дээрх арга хэмжээг хөтөлбөрийн дагуу цаг хугацаанд нь амжилттай зохион байгуулж, олон нийтэд хэвлэл мэдээллээр сурталчилах, хяналт тавих, шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг хотын аялал жуулчлал хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Баясгалан/-д даалгасугай.

ДАРГА

Ш.СҮХБААТАР



115050000085